



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/22/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Ахлах аудитор Б.Азхүү Утас: 9985-8616 Цахим хаяг: Azkhuub@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Зөвлөмж.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕГ	Татварын Ерөнхий газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.ЭРДЭНЭБИЛЭГ
ТАНАА

2022.02.27 № 27
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,482,271.22	43,722,992.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	8,750,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	8,750,000.00
31210	Төгрөг	0.00	8,750,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	0.00	8,750,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	31,482,271.22	34,972,992.52
35400	Хангамжийн материал	31,482,271.22	34,972,992.52
35410	Бичиг хэргийн материал	1,271,500.00	2,345,000.00
35420	Аж ахуйн материал	30,123,246.22	32,065,736.22
35440	Түлш, шатах тослох материал	87,525.00	515,616.30
35470	Бусад хангамжийн материал	0.00	46,640.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	512,159,798.80	485,411,615.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	512,159,798.80	485,411,615.37
39200	Биет хөрөнгө	482,949,798.80	456,201,615.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	287,254,097.44	287,254,097.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-24,479,844.96	-36,703,023.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	104,000,000.00	104,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,944,975.67	-40,338,868.97
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	207,443,968.93	238,432,728.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-63,277,746.78	-98,008,232.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,663,020.00	31,663,020.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,708,720.16	-30,098,105.81
39300	Биет бус хөрөнгө	29,210,000.00	29,210,000.00
39301	Програм хангамж	309,611.72	309,611.72
39302	Хуримтлагдсан элэгдэл	-309,611.72	-309,611.72
39303	Бусад биет бус хөрөнгө	29,210,000.00	29,210,000.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	543,642,070.02	529,134,607.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	543,642,070.02	529,134,607.89
51	Засгийн газрын хувь оролцоо	543,642,070.02	529,134,607.89
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	541,027,994.00	541,027,994.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-165,903.45	-14,673,365.58
51210	Өмнөх үеийн үр дүн	-114,979,974.87	-165,903.45
51220	Тайлант үеийн үр дүн	114,814,071.42	-14,507,462.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,779,979.47	2,779,979.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	543,642,070.02	529,134,607.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	931,039,677.59	906,730,630.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	168,884,177.59	49,419,730.00
120	Нийтлэг татварын бус орлого	168,884,177.59	49,419,730.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	168,884,177.59	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	444,500.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	129,473,538.43	30,218,760.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	38,966,139.16	19,200,970.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	762,155,500.00	857,310,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	761,010,500.00	853,235,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	761,010,500.00	853,235,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,145,000.00	4,075,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,145,000.00	4,075,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	816,036,445.76	921,238,092.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	816,036,445.76	921,238,092.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	801,645,332.15	909,945,204.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,576,993.39	600,396,685.00
210101	Үндсэн цалин	391,733,397.39	386,171,860.00
210102	Нэмэгдэл	84,354,721.00	88,022,939.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,069,000.00	54,210,000.00
210104	Урамшуулал	50,419,875.00	71,991,886.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,005,100.00	79,750,148.86
210201	Тэтгэврийн даатгал	46,974,878.39	55,336,894.10
210202	Тэтгэмжийн даатгал	5,526,458.40	6,160,017.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,401,002.07	4,867,534.90
210204	Ажилгүйдлийн даатгал	1,100,254.34	1,216,865.04
210205	Эрүүл мэндийн даатгал	11,002,506.80	12,168,836.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,533,694.00	45,622,506.00
210301	Гэрэл, цахилгаан	2,749,635.00	2,724,777.00
210302	Түлш, халаалт	40,406,400.00	40,406,448.00
210303	Цэвэр, бохир ус	1,377,659.00	2,491,281.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,027,208.64	29,154,131.70
210401	Бичиг хэрэг	8,304,877.00	7,019,700.00
210402	Тээвэр, шатахуун	4,608,122.70	5,415,908.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,299,288.00	5,071,028.00
210404	Ном, хэвлэл	971,800.00	252,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	161,100.00	147,870.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,535,020.94	9,227,185.00
210408	Бараа материал актгалсны зардал	1,147,000.00	2,019,840.00
2105	Нормативт зардал	0.00	16,643,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	16,643,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,690,100.00	6,638,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	18,600.00
210604	Урсгал засвар	3,690,100.00	6,620,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,995,800.00	5,610,400.00
210702	Дотоод албан томилолт	4,995,800.00	5,610,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,835,787.00	54,025,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,479,375.00	49,748,700.00

Архангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	554,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	873,200.00	873,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184,596.00	181,390.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	3,158,860.00
210807	Газрын төлбөр	13,310.00	17,210.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	687,306.00	1,760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,980,649.12	72,103,713.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,000.00	6,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,404,000.00	7,866,770.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,415,649.12	57,736,943.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,391,113.61	11,292,887.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,145,000.00	1,075,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,145,000.00	1,075,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,801,613.61	10,217,887.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,801,613.61	10,217,887.14
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	444,500.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	444,500.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	115,003,231.83	-14,507,462.13
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	189,160.41	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	189,160.41	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	114,814,071.42	-14,507,462.13

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,027,994.00	2,779,979.47	-114,397,697.87	429,410,275.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-582,277.00	-582,277.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	541,027,994.00	2,779,979.47	-114,979,974.87	428,827,998.60
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	114,814,071.42	114,814,071.42
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,027,994.00	2,779,979.47	-165,903.45	543,642,070.02
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	541,027,994.00	2,779,979.47	-165,903.45	543,642,070.02

Архангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	541,027,994.00	2,779,979.47	-165,903.45	543,642,070.02
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-14,507,462.13	-14,507,462.13
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	541,027,994.00	2,779,979.47	-14,673,365.58	529,134,607.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	762,600,000.00	866,194,802.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	444,500.00	8,750,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	444,500.00	8,750,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	444,500.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	444,500.00	0.00
120009	Бусад орлого	0.00	8,750,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	762,155,500.00	857,444,802.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	761,010,500.00	853,235,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	761,010,500.00	853,235,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,145,000.00	4,075,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,145,000.00	4,075,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	133,902.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	133,902.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	755,991,000.00	856,674,802.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	755,991,000.00	856,674,802.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	741,599,886.39	845,248,012.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,576,993.39	609,146,685.00
210101	Үндсэн цалин	399,238,018.39	357,285,682.00
210102	Нэмэгдэл	79,632,593.00	116,909,117.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,779,000.00	54,210,000.00
210104	Урамшуулал	48,927,382.00	80,741,886.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,005,100.00	79,750,148.86
210201	Тэтгэврийн даатгал	46,974,878.39	55,336,894.10
210202	Тэтгэмжийн даатгал	5,526,458.40	6,160,017.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,401,002.07	4,867,534.90
210204	Ажилгүйдлийн даатгал	1,100,254.34	1,216,865.04
210205	Эрүүл мэндийн даатгал	11,002,506.80	12,168,836.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,533,694.00	45,622,506.00
210301	Гэрэл, цахилгаан	2,749,635.00	2,724,777.00
210302	Түлш, халаалт	40,406,400.00	40,406,448.00
210303	Цэвэр, бохир ус	1,377,659.00	2,491,281.00

Архангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	20,663,918.00	26,245,313.00
210401	Бичиг хэрэг	3,579,890.00	7,168,300.00
210402	Тээвэр, шатахуун	4,296,000.00	5,844,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,299,288.00	5,071,028.00
210404	Ном, хэвлэл	446,200.00	432,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	161,100.00	147,870.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,881,440.00	7,581,515.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,718,900.00	7,618,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	998,600.00
210604	Урсгал засвар	6,718,900.00	6,620,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,995,800.00	5,610,400.00
210702	Дотоод албан томилолт	4,995,800.00	5,610,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,350,481.00	57,777,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,479,375.00	49,748,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	554,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	873,200.00	873,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184,596.00	184,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,202,000.00	6,912,860.00
210807	Газрын төлбөр	13,310.00	14,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,755,000.00	13,477,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,351,000.00	6,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,404,000.00	6,977,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,391,113.61	11,426,789.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,145,000.00	1,208,902.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0.00	133,902.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,145,000.00	1,075,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,801,613.61	10,217,887.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,801,613.61	10,217,887.14
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	444,500.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	444,500.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,609,000.00	9,520,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,609,000.00	770,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,609,000.00	770,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,609,000.00	770,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,609,000.00	770,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-6,609,000.00	-770,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	8,750,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	8,750,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	853,235,900.00	843,018,012.86	10,217,887.14	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	853,235,900.00	843,018,012.86	10,217,887.14	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	853,235,900.00	843,018,012.86	10,217,887.14	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	615,694,700.00	609,146,685.00	6,548,015.00	98.9
210101	Үндсэн цалин	362,073,200.00	357,285,682.00	4,787,518.00	98.7
210102	Нэмэгдэл	107,553,200.00	116,909,117.00	-9,355,917.00	108.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,080,000.00	54,210,000.00	3,870,000.00	93.3
210104	Урамшуулал	87,988,300.00	80,741,886.00	7,246,414.00	91.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,036,800.00	79,750,148.86	3,286,651.14	96.0
210201	Тэтгэврийн даатгал	58,409,000.00	55,336,894.10	3,072,105.90	94.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,156,900.00	6,160,017.94	-3,117.94	100.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,925,600.00	4,867,534.90	58,065.10	98.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,231,400.00	1,216,865.04	14,534.96	98.8
210205	Эрүүл мэндийн даатгал	12,313,900.00	12,168,836.88	145,063.12	98.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,740,200.00	45,622,506.00	117,694.00	99.7
210301	Гэрэл, цахилгаан	2,813,400.00	2,724,777.00	88,623.00	96.8
210302	Түлш, халаалт	40,406,500.00	40,406,448.00	52.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,520,300.00	2,491,281.00	29,019.00	98.8
2104	Хангамж, бараа материалын зардал	26,945,900.00	26,830,773.00	115,127.00	99.6
210401	Бичиг хэрэг	7,170,000.00	7,168,300.00	1,700.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	5,844,000.00	5,844,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,088,500.00	5,071,028.00	17,472.00	99.7
210404	Ном, хэвлэл	433,400.00	432,600.00	800.00	99.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	243,000.00	147,870.00	95,130.00	60.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,167,000.00	8,166,975.00	25.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,620,000.00	4,618,600.00	1,400.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	998,600.00	1,400.00	99.9
210604	Урсгал засвар	3,620,000.00	3,620,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	5,668,000.00	5,610,400.00	57,600.00	99.0
210702	Дотоод албан томилолт	5,668,000.00	5,610,400.00	57,600.00	99.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,053,300.00	57,961,900.00	91,400.00	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,840,100.00	49,748,700.00	91,400.00	99.8
210803	Даатгалын үйлчилгээ	873,200.00	873,200.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184,600.00	184,600.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	0.00	100.0

Архангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,097,400.00	7,097,400.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	14,000.00	14,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,477,000.00	13,477,000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,500,000.00	6,500,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,977,000.00	6,977,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	853,235,900.00	843,018,012.86	10,217,887.14	98.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	853,235,900.00	843,018,012.86	10,217,887.14	98.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	853,235,900.00	843,018,012.86	10,217,887.14	98.8
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	8,750,000.00	-8,750,000.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43.00	41.00	2.00	95.3
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	38.00	36.00	2.00	94.7
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1.00	1.00	0.00	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	39.00	37.00	2.00	94.9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,075,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,075,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,075,000.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,075,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,075,000.00
	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,075,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,075,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,075,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,075,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азхүү гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Татварын хэлтэс нь Татвар төлөгч хуулиар хүлээсэн татвар төлөх үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгтэй байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд дараах зорилтуудыг тавин ажилласан байна. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдэллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах,
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих,
- Төсвийн орлого бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Татварын ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.6.6 дахь заалтын "63.2-т" гэснийг "119.2-т" гэж өөрчилсүгэй гэж 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, "34.13.4.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, өөрчлөлттэй холбоотой мэдээллийг тухай бүр" гэсэн заалтад 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр тус тус өөрчлөлт орсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд ТЕГ-ын Дотоод хяналт шалгалтын хэлтсээс 2021 онд төлөвлөгөөт шалгалтыг хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 853.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 8.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 5.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 14.5 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Мөнгөн хөрөнгө	0	8.7	8.7	
Бараа материал	31.5	35.0	3.5	11.1
Үндсэн хөрөнгө	512.1	485.4	(26.7)	(5.2)
Нийт хөрөнгө	543.6	529.1	(14.5)	(2.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	543.6	529.1	(14.5)	(2.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	543.6	529.1	(14.5)	(2.6)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Тайлант онд ахмадын сан байгуулж 8.7 сая төгрөгийг цалингаас сангаас шилжүүлж мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.
- Бараа материал эхний үлдэгдлээс 11.1 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 31.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 38.6 төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 19.2 сая төгрөг нийт 57.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 54.3 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 35.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 26.7 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 512.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 0.8 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 30.2 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 57.7 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 485.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл тайлант хугацааны алдагдлаар буурсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт /сая.төгрөг/ 3=2-1
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	761.00	853.2	92.2
Нэмэлт санхүүжилтийн орлого	1.1	4.0	2.9
Татварын бус орлого	168.8	49.4	(119.4)
Үйл ажиллагааны орлого	931.0	906.7	(24.3)
Цалин, шимтгэлийн зардал	609.5	680.1	70.6
Бусад бараа үйлчилгээний зардал	154.0	181.5	27.5
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39.8	54.0	14.1
Бараа үйлчилгээний бусад зардал	12.5	14.3	1.8
Хөрөнгө шилжүүлсэн			0
Үйл ажиллагааны зардал	816.0	921.2	105.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	115.0	(14.5)	(129.5)

Аймгийн Татварын хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 92.5 сая төгрөгөөр буюу 12.1 хувиар өссөн нь цалин хөлсний зардал үр дүнгийн урамшуулал, унаа хоолны зардал өсөж батлагдсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,193.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 340.4 сая төгрөгөөр хасаж, нийт зардлыг 853.2 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Төсвийн төсөл хасагдсан нь албан конторын өргөтгөл, их засвар, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлууд хасагдсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 853.2 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр 843.0 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 10.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь цалин хөлсний урсгал зардлуудтай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДТГ-аас 3.0 сая төгрөгийг конторын барилгын засвар үйлчилгээний зардал, 1.1 сая төгрөгийг аймгийн шилдэг татвар төлөгчдийн шагналын зардал, нийт 4.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд малын тоо толгойн албан татвар хураах, малчин, мал бүхий иргэдээс албан татварын тайлан гаргуулах ажлууд хийгдсэн, татварын албаны үйлчилгээг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлж албан татварыг пос машин, э-баримт, киоск, э-монголиа, смарткар зэргээр төлөх боломжтой болсон байна.

Татварын Ерөнхий газраас 2021.08.09-ны өдөр 31 ширхэг 16.8 сая төгрөгийн үнэ бүхий Татварын улсын байцаагчийн дүрэмт хувцасыг аймгийн татварын хэлтэст ирүүлсэн байна. Энэ нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.4 дэх заалттай нийцэхгүй байгаа тул дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн тайланд үргэлжлүүлэн авч үзэх нь зүйтэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92.8 хувьтай байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. МУЗГ-ын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.1 дэх заалтыг дагуу зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлаас 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргасан эсэхийг тулган шалгахад 16.4 сая төгрөгийн хэмнэлт гаргаж төсөвт төвлөрүүлэх байсан боловч 10.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Тухайн байгууллага нь тогтоолын энэхүү заалтыг мөрдөж ажиллах боломжгүй байсан талаар тайлбар тодруулгыг ирүүлсэн байна.
2. Суудлын автомашин ашиглалтын хувьд: Ланд-76 маркийн авто машин нь 2018 онд ашиглалтад орсон 89.0 сая төгрөгийн анхны өртөгтэй, шатахууны зардалд 0.9 сая төгрөг, Приус-30 маркийн авто машин нь 2018 онд ашиглалтад орсон 15.0 сая

төгрөгийн анхны өртөгтэй, шатахууны зардалд 3.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 12.1 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аймгийн Татварын хэлтэс нь 2021 онд нийт 218.8 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомж

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.1 дэх заалтыг дагуу зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлаас 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргасан эсэхийг тулган шалгахад 16.4 сая төгрөгийн хэмнэлт гаргаж төсөвт төвлөрүүлэх байсан боловч 10.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Тухайн байгууллагаас ирүүлсэн тайлбар, нөхцөл байдлыг үнэлж аудитаас шийдвэр өгөөгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт бүрэн нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож оруулсанд зөвлөмж өгч, шийдвэрийг хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгө худалдан авахдаа ямар зардлаас бэлтгэсэн болон МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлээ.

4.1 Зөвлөмж

Төсвийн зарцуулалттай холбоотой.

Илрүүлэлт: Тус байгууллага нь бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс болон мэдээлэл технологийн зардлаас 770.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталса “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтын дагуу төсвийг зориулалтын дагуу зарцуулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй, таслан зогсоох арга хэмжээ авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Архангай аймгийн Татварын хэлтэс	1	0.8	0	0	0	0	0	0	1	0.8
Дүн		1	0.8							1	0.8
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2		0	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн		1	0.8							1	0.8